

**ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ БОЛОН ӨВӨР МОНГОЛ ХЭЛНИЙ
ХЭРЭГЛЭЭНИЙ ҮГСИЙН САНГИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

*(Хятад улсын Өвөр Монгол хийгээд Монгол улсын
9, 10 сарын олон улсын мэдээний жишээн дээр)*

Саруул*

Монгол хэл бол МУ, БНХАУ, ОХУ-ын хүн амын зарим хэсэг хэлэлцдэг хэл юм. Хятад улсад Өвөр монгол, Шинжаан, Хөхнуур зэрэг газар орны монголчууд хэрэглэдэг. Дээр дурдсан газар орны монголчуудын хэрэглэж буй үгс монгол хэлний хэрэглээний үгсийн санг бүрдүүлдэг. Эдүгээ монгол хэлний хэрэглээний үгсийн сан нь монгол хэлний хил алслан хэрэглэгдэж байгаа хэрэглээний онцлог шинж хийгээд нийгэм, түүхийн учир шалтгаанаас болж, тухайн улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг дагалдан, өөр өөрийнхөө дүрэм журмаар хөгжин баяжиж байна. Аливаа мэдээлэл интернетээр дамжин дэлхий дахинд түгэж байгаа энэ цаг үед, Хятад Монгол хоёр улсад монгол хэлээр гарч буй сэтгүүл, ном зохиол, хүмүүсийн харилцаан дахь монгол хэл, хэрэглээний байдлаас хамаарч хоёр орны монгол хэлний хэрэглээний үгсийн сангийн зөрөө нь улам тодрон, монгол хэлний хэрэглээний үгсийн санг газар орноор нь нэгжлэн харьцуулан судлах боломжтой болж байна.

Бид Монгол улс хийгээд Өвөр Монголын 9, 10-р сарын олон улсын мэдээг хооронд нь харьцуулан шинжилж, ямархүү адил бус зүйл оршиж байгааг ажиглан судлав. Шинжлэх ухаан, техник мэрэгжлийн хөгжлийг дагалдан нэр томъёо улам олширч байгаа өнөө үед, зарим нэр томъёог тогтвортой хэрэглэж, зарим нэр томъёог өөр нэр томъёогоор орлуулан, эсвэл нэг үзэгдэл, ухаагдахуун, ойлголтыг хэд хэдэн нэр томъёогоор илэрхийлэх тогтворгүй байдлыг бий болгожээ. Сонин хэвлэлийн мэдээнд хэрэглэж байгаа нэр томъёо бол хамгийн шинэлэг, ойлгоход дөхөм мөртөө оновчтой. Монгол Улс ба Өвөр монголд яг адилхан хэрэг явдлыг мэдээлж ярихад, хэрэглээний үгсийн сангийн талаар ямар ямар адил бус тал байгаа, үг өгүүлбэр, найруулгын талаар ямар ямар өвөрмөц байдал харагдаж буй зэргийг харьцуулан судлахыг зорьсон болно.

Монгол улс хийгээд Хятад улсын Өвөр Монголын 9, 10-р сарын олон улсын мэдээний үг хэллэгийг судалбаас, орчин цагийн монгол ба Өвөр Монгол үг хэллэгийн өвөрмөц онцлог үзэгдэл нь үндсэндээ нэр томъёо, үйл явдал, үйл хөдөлгөөн болж байгаа байдал, түүний онцлог шинжийг зааж тодорхойлсон үг хэллэг, найруулга зэрэг талаар илэрч байна. Монгол улс хийгээд Хятад улсын Өвөр Монголын 9,10-р сарын олон улсын мэдээний үг хэллэгийн өвөрмөц талыг доорх маягаар ангилж болмоор байна.

* Өвөр Монголын Их Сургуулийн МСДС

Нэг. Нэр томъёоны талаар:

Бидний мэдэж байгаагаар, дэлхий дахины шинжлэх ухаан техник мэргэжил хөгжихийн хамт шинэ нэр томъёо олноор зохиогдож буй. Иймээс Монгол хэлний нэр томъёог эмхэтгэн цуглуулж, хянан тогтоох ба дүрэмжүүлэн нэгтгэх ажил чухал байна. Монгол улс хийгээд Хятад улсын Өвөр Монголын 9, 10-р сарын олон улсын мэдээний үг хэллэгийг харьцуулахад нэр томъёоны хэрэглээнд доорх зүйл ажиглагдаж байна.

1. Орчин цагийн монгол хэл ба Өвөр монгол үг хэллэгт адил бус уугуул монгол үгээр ижил утгат нэр томъёог илэрхийлсэн байдал олон байна. Жишээлбэл:

Өвөр. Монг.	Орчин. Монг.	Хятад. Үгчилсэн орчуулга.	Англ.
нисгэл	онгоц	飞机(нисэх машин)	plane
эедүүлэгч	эвсүүлэгч	协调角色 (зохицох тохируулах дүр)	coordinator
эндэл	гэмтэл	故障 (эндэл саад)	troubles
жишигдэгч	нэр дэвшигч	候选人 (сонгох хүн)	candidate
хадгалагдагч	нооцийн хэмжээ	储量(хадгалах хэмжээ)	reserves
зөвлөлцөөр	хэлэлцээр	协议 (зохицох зөвлөлгөө)	protocol
үйлдэхүүн	бүтээгдэхүүн(бэлэн бүтээгдэхүүн)	产品 (үйлдэхүүн эд)	product
уналт	гарц/ургац	产量 (гаралт хэмжээ)	output
зарлиг	тушаал	命令 (зарлиг)	standby
хүүр	цогцос	遗体 (үлдэгдэл бие)	corpse
шатаалга(түши)	шатахуун(шатахуун түши)	燃料 (шатах материал)	fuel
сул хувцас	энгийн хувцас	便装 (энгийн хувцас)	everyday clothes
эндсэн нисгэл	осолдсон онгоц	失事飞机 (алдах явдал нисэх машин)	crashed plane
сүр үзүүлэгчид	эсэргүүцэн жагсагчид	示威者 (үзүүлэх сурчин)	demonstrator
арилжааны тойрог	худалдааны дүүрэг	商业区 (худалдаа аж ахуй тойрог)	Industrial area
сүрдүүлэх этгээд	алан хядагч	恐怖分子(сүрдүүлэх айлгах этгээд)	terrorist
чимээрхэг хүмүүн	мэдээлэл сайтай хүн	消息人士 (чимээ хүн)	the source
дараа гараг	ирэх долоон хоног	下周 (дараа гараг)	next week
жилийн ой	ойн баяр\тэмдэглэлт ой	周年 (ой жил)	anniversary
дурсгах ажиллагаа	тэмдэглэх ёслол	纪念仪式 (тэмдэглэх дурсгах ёслол)	mourn
зохиомол хүрхрээ	усан оргилуур	人工瀑布 (хүний хүч хүрхрээ бүс)	artificial waterfall
ажлын голдлого	ажлын гол цөм	工作重点 (ажил хийх хүнд цэг)	focus
бэл оруулалт	хоронго оруулалт	投资 (оруулах бэл)	investment

дагуул одон	хиймэл дагуул	卫星 (хамгаалах од)	satellite
чулуун тос	газрын тос	石油 (чулуун тос)	oil
харимхай чанар	уян хатан чанар	弹性 (харимхай чанар)	elasticity
насжилын даатгалын мөнгө	өндөр насны тэтгэвэр	养老金 (тэжээх настан зоос)	pension
амар төвшиний баталгаа	аюулгүй байдлын баталгаа	安全保障 (амар төгөлдөр төвшин батлах гэрч)	security guarantees
сум дарийн хөмрөг	зэвсгийн агуулах	弹药库 (сум дарийн хөмрөг)	ammunition depot
зэмдэг хүмүүс гэх мэт.	саалттай хөгжлийн бэрхиээлтэй хүмүүс	残障人士 (зэмдэг саад хүн)	people with disabilities ...

Дээрх жишээнээс үзэхэд, уугуул монгол үгээс бүтсэн орчин цагийн монгол хэл болон Өвөр монгол хэлний дан үгээс бүтсэн нэр томъёо нь өвөрмөц байхаас гадна, холбоо үг бүтээсэн байдал ч өвөрмөц байгааг ажиглаж болно. Энэ мэт нэр томъёо хоёр улсын мэдээнд зуу гаруй тохиолдож байна. Үүнд дан үгийн нэр томъёоны тоо хэмжээ нь үг холбон бүтсэн нэр томъёоноос тооны хувьд бага. Хорь гаруй буй.

2. Орчин цагийн монгол хэлэнд хэрэглэж буй ормол нэр томъёог Өвөр Монгол хэлэнд уугуул монгол хэллэгээр илэрхийлсэн зүйл байна. Жишээлбэл:

Өвөр. Монг.	Орчин. Монг.	Хятад.	Үгчилсэн Англ.
		орчуулга.	
хоолон гэр	ресторон	餐厅 (хоол танхим)	restaurant
чулуун тос	нефть	石油 (чулуун тос)	oil
тавуулжис асар	пентагон	五角大楼 (тавуун өнцөг том асар)	pentagon
мөсөн бөмбөг	хоккей	冰球 (мөсөн бөмбөг)	Ice hockey
албаны сүлжээний өртөө	албан ёсны вэбсайт	官方网站 (албан тал сүлжээ өртөө)	official website
Хөл дэсээс хамтарсан уралдаан	хөл бөмбөгийн супер лигийн тэмцээн	足球超级联赛 (хөл бөмбөг давсан дэс хамтарсан уралдаан)	Super Football League
гуйвууламж	валютын хани	货币汇率 (зоос гуйвуулах норм)	currency exchange rates
гадаадаас оруулсан шатаалгийн ерөнхий өртөг	инпортын түлшийн нийт өртөг	进口燃料总值 (орох боомт шатах материалын ерөнхий өртөг)	total value of imports of fuel
цөмийн урвалын зуух	цөмийн реактор	核反应堆 (цөмийн урвалын зуух)	Nuclear reactor
чимээ агаар утас	холбооны антен	通讯塔天线 (нэвтрэх чимээ суврага агаар утас)	communications tower antenna

... гэх мэт.

Дээрх жишээнээс үзэхэд, уугуул монгол үгээс бүтсэн Өвөр монгол нэр томъёо нь бүгд үг холбон бүтжээ. Орчин цагийн монгол хэлний нэр томъёо нь дан ормол үг, уугуул монгол үг болон ормол үгээс бүтжээ. Орчин цагийн монгол хэлний ормол нэр томъёог ажиглавал, англи, орос зэрэг өрнөдийн хэлний үг хэллэг хэрэглэж буй. Өвөр монгол нэр томъёо нь хятад хэлний үгийг хуулбарлан орчуулж хэрэглэж байна. Иймэрхүү нэр томъёо хоёр талын мэдээнд дээрх жишээ мэтээр арав тохиолдлоо.

3. Өвөр Монгол хэлэнд хэрэглэж буй ормол нэр томъёог орчин цагийн монгол хэлэнд уугуул монгол хэллэгээр илэрхийлсэн зүйл бас ажиглагдаж байна. Жишээлбэл:

Өвөр. Монгол.	Орчин. Монгол.	Хятад. Үгчилсэн орчуулга.	Англи.
айз өвчний вирус халдварлагдсан	ДОХ-ын халдвар авсан	感染了艾滋病 (халдварласан аийз өвчний вирус)	(infected with HIV)
63 билет зөвшөөрч, 35 билет эсэргүүцсэн тайфэн салхи	63 дэмжих санал, 35 эсрэг санал далайн салхи хар	63票赞成、35票反对 (63 билет зөвшөөрч, 35 билет эсэргүүцсэн) 台风	63 votes in favor and 35 votes against Typhoon...

гэх мэт.

Дээрх жишээнээс үзэхэд, Өвөр монгол хэлэнд ормол шинжтэй нэр томъёо нь монгол хэлэнд орж нэгэнт идээшин тогтворжсон монгол үг хэллэг болжээ. Иймэрхүү нэр томъёо хоёр улсын мэдээнд дээрх жишээ мэтээр гурав тохиолджээ. Гэхдээ Өвөр монгол хэлэнд хэрэглэгдэх ормол нэр томъёоны тоо хэмжээ нь орчин цагийн монгол хэлтэй харьцуулахад нэлээд бага байх нь илэрхий.

4. Зарим албан тушаал, засаг захиргаа, албан байгууллагын нэр томъёоны адил бус.

Өвөр. Монгол.	Орчин. Монгол.	Хятад.	Англи.
дэд даамал	орлогч дарга	副总经理	deputy general manager
бүх гамшигийн хамааралтын зохион байгуулалтын албан тушаалтан	бүх улсын байдлын газрын албан тушаалтан	全国灾害管理组织官员	Officials of the National Disaster Management Organization
онц томилсон бүлгэм	тусгай бүлэг, хэсэг	特派团	Mission
өндөр зэргийн шүүх хороо	дээд шүүх	高等法院	High Court
олон улсын холбоот байгуулага	НҮБ (Нэгдсэн үндэстний байгууллага)	联合国	United Nations
олон нийтийн байцаагчийн албан гэр	шүүх прокурорын газар	公共检察官办公室	Public Prosecutor's Office
дэлхийн нүүдэл	дүрвэгчдийн	国际移民组织	International

ардын байгуулалт	зохион асуудлыг олон байгууллага(цагаач иргэд)	шийдэх улсын		Organization for Migration
амар төвшиний салаа мөчир	хамгаалах хэлтэс	албаны	安全部门	The security services
загасны хөгжилт хаммааралтын үйлс гамшигийг аргацаах салаа мөчир	үйлсийн ба онцгой салбар	эрхлэх аж ахуй	渔业发展和管理事业	Fisheries development and management
гал унтраах салаа мөчир	гал салбар(галын аюулаас хамгаалах)	сөнөөх	消防部门	Disaster Prevention Department Fire department
сургаан хүмүүжлийн салаа мөчир	боловсролын хэлтэс		教育部门	Education sector
бачим аргацаах яам	байдлыг онцгой байдлын яам		紧急情况部	Ministry of Emergency Situations
түргэн аврах салаа мөчир	яаралтай тусламж үзүүлэх анги		急救部门	Emergency department
улсын хамгаалалтын орон байгалийн тойрон зугаацлын яам	байгалийн орчин болон аялал яам	дархан цаазат газар Байгаль орчин, жуулчлалын	国家自然保护区 自然环境和旅游部	national nature reserve Ministry of Natural Environment and Tourism ...

гэх мэт.

Дээрх жишээнээс үзэхэд, Орчин цагийн монгол хэл болон Өвөр монгол хэлний зарим албан тушаал, засаг захиргаа, албан байгууллагын нэр томъёоны адил бус тал нь үг хэллэгийн зөрүүгээр илрэхээр үл барам бүрдүүлсэн үгийн тоо хэмжээ нь бас өвөрмөц байна. Олонх байдалд Өвөр монгол хэлний эдгээр нэр томъёог бүрдүүлсэн үгийн тоо нь Монгол улсын монгол хэлний нэр томъёоныхоос илүү. Өвөр монгол хэлний нэр томъёоны зүйлд хятад хэлний үгийг хуулбарлан орчуулсан нь бас бий. Иймэрхүү нэр томъёо хоёр улсын мэдээнд дөч орчим тохиолдож байна.

5. Орчин цагийн монгол хэл ба Өвөр монгол хэлэнд ормол үгээс бүтсэн ижил утгат нэр томъёо хэрэглэж байна. Жишээлбэл:

Өвөр. Монгол.	Орчин. Монгол.	Хятад.	Англи.
киноны найр	кино наадам	电影节	Film Festival
киноны ордон	кино театр	电影院	Cinema
чулуун тосны компани	нефть компани	石油公司	oil-company
олимпыкийн тамирын чуулган	олимп	奥运会	Olympic Games
зэмдэгчүүдийн	паролимп	残奥会	Paralympic Games

олимпын тамирын

чуулгаан

цахилгаан хучний цахилгаан эрчим 电力公司 power company

компани хучний компани

дээд дэсийн генерал дэслэгч генерал 中将 Lieutenant ...

гэх мэт.

Дээрх жишээнээс үзэхэд, Монгол улс болон Өвөр монгол хэлэнд кино, компани, генерал хэмээх үгс адил хэрэглэж байна. Энэ мэт нэр томъёо хоёр улсын мэдээнд долоон удаа тохиолдлоо.

Үйл явдал, үйл хөдлөл, түүний онцлог шинжийг зааж тодорхойлсон үг хэллэгт өвөрмөц байдал нэлээд ажиглагдав.

Хоёр. Үйл явдал, үйл хөдөлгөөн болж байгаа байдал, түүний онцлог шинжийг заасан үг хэллэг:

Өвөр. Монг. данслуулсан	Орчин. Монг. бүртгүүлсэн	Хятад. Үгчилсэн орчуулга. 登记 (тавих тэмдэглэх)	Англ. registrate
цэвдэглүүлсэн (үл хөдөлгөх, хорих)	царцаасан (хориглон хаах, зогсонги байдалд байлгах, хөдөлгөхгүй, б итүүлэх)	冻结	freeze
сонсолтоор	дам мэдээллээр	据悉 (үндэслэх сонсох)	It is reported that
эрхийлэгдсэн	эзлэгдсэн	控制 (эрхийлэх хязгаарлах)	control
тэвчигдсэн	эс зөвшөөрөгдсөн	禁止 (цаазлах хорих)	refuse
бүлгэмдэх	санал нэгдэх	保持团结 (баримтлах бүлгэмдэл)	to maintain unity
гуйчилсан	хүссэн	请求 (хүсэх гуйх)	request
үүргэлэх	даан авах	担任 (үүргэлэх хариуцах)	take the office of
мэнчүүрүүлсэн ахдахдаа	мэдээ алдруулсан удахдаа	麻醉的 (минчүүрэх согтох) 至多 (хүртэл олон)	anesthetized at most ; at the longest
бачим	яаралтай	紧急 (бачим яаралтай)	urgent
залхаал үзүүлэх	хориг арга хэмжээ авах (цээрлэл үзүүлэх)	制裁	apply sanctions; impose sanctions
үхэл шархдал гарахаас зайлсхийх	хохирлоос сэрэмжлэх	避免伤亡 (зайлах хэлтрэх шархдалүхэл)	Avoid casualties
утас нэвтрээд	утсаар яриад	通了电话 (нэвтэрэх цахилгаан үг)	be on the telephone with
бутраан явуулжээ	тараажээ	驱散 (бутраах тархаах)	scatter

гүйчиллаан дэвшүүлэх	хүсэлтээ гардуулах	提交诉求(гаргаах тушаах тоочих гүйчлэх)	submit an application
хамтралцаа хийх	хамтын ажиллагаа хөгжүүлэх	开展合作(нээх явагдах хамтрах ажил)	cooperate
буруугаа мэдрэв	уучлал эрэв	表达歉意(илтгэх буруу)	expression of regret
эрхээ хаяна	тушаалаас огцорно	放弃权力(хаях эрх)	give up power
гуйвууламж доогуур жишигдсэн ялаа мэдрэв	валютын ханиийг дутуу үнэлсэн	汇率被低估(гуйвуулах норм доор жиших)	undervalue exchange rate
дэмий үгүй	хомс	认罪(мэдрэх ял)	confess guilty
хэлэлгээн үгүй	эргэлзээгүй	不多 (үгүй олон)	not much
дэмий хол үгүй	тун удахгүй	显然是(илэрхий тийм)	of course
		不会太长(үгүй чадах тун урт)	not too long

... гэх мэт.

Энэ мэт жишээ наяд гаруй тохиолджээ. Хоёр улсын мэдээнд хэрэглэж буй эдгээр үгсийг шинжвэл, орчин цагийн монгол хэл болон Өвөр монгол хэлэнд бүр хэрэглэж байгаа юм. Гэвч өдөр тутмын хэрэглээнд өвөрмөц байна.

Гурав. Найруулгын талаар:

1. Өвөр монголын мэдээнд үйл үгийн үйлдэгдэх хэвийн дагавар, харин Монгол улсын мэдээнд үйл үгийн үйлдэх хэвийн дагаврыг идэвхтэй хэрэглэх аж.

Өвөр. Монгол.	Орчин. Монгол.	Хятад. Үгчилсэн орчуулга.	Англи.
явуугдуулж	болох	为	become
явуугдав	болов	举行(өргөх явах)	hold in
шилжүүлэгдэж	нүүлгээж	转移(солих шилжих)	shift
зарлигдсан	тушаах	下令(буулгах зарлиг)	require
явагдаж	хийж, зохион байгуулж	进行(орох явах)	conduct
нөлөөлөгджээ	ажил саатжээ	受到影响(хүртэх нөлөөлөл)	affected
явуугдуулж	явуулж	进行(орох явах)	conduct, carry on
явуугдуулна	явуулна	进行(орох явах)	conduct, carry on
заалдагдав	зарга мэдүүлэв	被控(заалдагдах)	charged with
заалдагдсан	ялалсан, шүүсэн	指控(заах заалдах)	charge
явагдсан	зохион байгуулах	举办(өргөх хийх)	hold...

ГЭХ МЭТ.

2. Өвөр монгол хэлний найруулга зүйг үзвэл хятад хэлнээс хуулбарлан орчуулж байгаа нь ажиглагдав. Үүний тухай дээр дурдсан билээ.

Өвөр. Монгол.	Орчин. Монгол.	Хятад. Үгчилсэн орчуулга.	Англи.
---------------	----------------	---------------------------	--------

хавсралага доор	дэмжилгээр	帮助下(хавсралага доор)	under the help
урсгагдан эвдэгдэв	усанд автав	冲毁(урсгагдан эвдэгдэв)	destroyed
шатагдаж сүйджээ	шатжээ	被烧毁	burned...

ГЭХ МЭТ.

Дээрх жишээтэй адилаар хятад хэлнээс хуулбарлан орчуулж хэрэглэх байдал Өвөр монголын мэдээнд нэлээд тохиолдлоо. Энэ нь Өвөр монгол хэлний хөгжлийн орчин ахуйгаас шалтгаалж, Орчин цагийн монгол хэлнээс ялгарах өвөрмөц талтай болжээ.

3. Өвөр монголын мэдээнд зарим нэр томъёо, байгууллагын нэрийг тогтворгүй хэрэглэх нь бий.

Өвөр. Монгол.	Орчин. Монгол.	Хятад.	Үгчилсэн	Англи.
		орчуулга.		
далайн хүрхрээ	цунами	海啸	далай хүрхрээ	Tsunami
далайн хүрхрэл	цунами	海啸	далай хүрхрэл	Tsunami
газар зүйн хайн шинжилгээний товчоо	геологи хайгуулын газар	地质勘探局(газар шинжилгээ хайн шинжлэх товчоо)		Geological Survey
газар шинжилгээний хайн шинжлэх товчоо	геологи хайгуулын газар	地质勘探局(газар шинжилгээ хайн шинжлэх товчоо)		Geological Survey
улсын гамшигийн хамааралтын товчоо	аюул улсын гамшигийн харгалзах товчоо	国家灾难管理局(улс гэр гамшиг аюул хамаарах товчоо)		National disaster management authority
улсын гамшигаас сэргийлэх хамааралтын товчоо	улсын гамшигийн харгалзах товчоо	国家灾难管理局(улс гэр гамшиг аюул хамаарах товчоо)		National disaster management authority
дэлхийн зоосны суурь мөнгөний зохион байгуулалт	олон улсын валютын сан	国际货币基金组织(олон улсын зоосны суурь мөнгөн зохион байгуулалт)		International Monetary Fund
олон улсын зоосны суурь мөнгөний зохион байгуулалт	олон улсын валютын сан	国际货币基金组织(олон улсын зоосны суурь мөнгөний зохион байгуулалт)		International Monetary Fund
гамшигийг сэргийлэх гамшигийг багасгаах тэнхим	гамшигаас сэргийлэх газар	防灾减灾厅(сэргийлэх гамшиг багасгаах гамшиг тэнхим)		Disaster Prevent and Reduce Department
гамшигийг сэргийлэх гамшигийг багасгаах захиргаа	гамшигаас сэргийлэх газар	防灾减灾厅(сэргийлэх гамшиг багасгаах гамшиг тэнхим)		Disaster Prevent and Reduce Department...

ГЭХ МЭТ.

4. Хоёр улсын мэдээнд тооны нэр өвөрмөц байна.

Өвөр. Монгол.	Орчин. Монгол.	Хятад.	Англи.
23.1 түмэн доллар	2 сая 310 мянга америк доллар	23.1 万美元	\$231,000
70 дүнчүүр гэх мэт.	7 тэрбум	70 亿	7 billion...

Товч дүгнэлт

Өнөөгийн Монгол улс болон БНХАУ-дахь Өвөр монголын хэлний байдлыг үгсийн сан, найруулга, хэрэглээний талаас нь харьцуулахын тулд олон улсын мэдээг сонгов. Учир нь тэр мэт мэдээнд хэрэглэж байгаа үг хэллэг нь олон улсад тогтсон нэр томъёо байдаг тул харьцууллыг зөв болгоход тустай гэж үзсэн билээ. Энэхүү судалгааг хийхийн тулд хятад улсын Өвөр Монголын 2011 оны 9,10-р сарын олон улсын мэдээнд үндэслэв. Тухайлан авсан 2 сарын мэдээнд өдий төдий зөрөөтэй үг хэллэг байсныг түүвэрлэн авч судалсан бөгөөд өгүүллийн хэмжээнд тохируулан цөөн жишээг эш татлаа. Түүнийгээ хэдэн зүйлээр ангилан, тус бүрт нь зүйлчилж ажигласан онцлогоо тайлбарласан болно.

Бид дараах дүгнэлтэнд хүрч байна.

1. Нэр томъёоны хувьд орчин цагийн монгол хэлэнд олон улсын чанартай ормол нэр томъёог идэвхтэй хэрэглэж байгаа бол, Өвөр монгол хэлэнд хятад хэлнээс хуулбарлан орчуулсан нэр томъёог идэвхтэй хэрэглэнэ.

2. Нэр томъёоны талаарх ерөнхий байдлыг ажиглавал, хоёр улсын 9,10 сарын мэдээнд уугуул монгол үгээр бүтсэн ижил утгатай ижил бус хэлбэрээр илэрхийлж байгаа нэр томъёо нь хамгийн олон тохиолдож байна.

3. Хоёр улсын мэдээнд үйл явдал, үйл хөдөлгөөн болж байгаа байдал, түүний онцлог шижийг зааж байгаа үгийг өвөрмөц байдлаар хэрэглэж байх нь сонирхолтой юм.

4. Найруулгын талаар, Өвөр монгол хэлэнд үйл үгийн хэвийн үйлдэгдэх хэвийн дагаврыг идэвхтэй хэрэглэх ажээ. Тооны нэрийн тухайд, түмээр суурь болгож, арван түм, зуун түм, мянган түм, дүншүүр гэж хэлэлцэнэ. Орчин цагийн монгол хэлэнд, үйл үгийн хэвийн үйлдэх хэвийг идэвхтэй хэрэглэж, үгийн сангийн бүрэлдхүүн болох үгсээ түүний найруулгын үүргээр нь оновчтой хэрэглэж буй. Тооны нэрийн тухайд, мянгаас сая хүртлэх тоог мянгаар суурь болгож, арван мянга, зуун мянга гэж хэлэлцэнэ.

Эцэст нь дүгнэн өгүүлэхэд, БНХАУ-ын Өвөр Монгол болон Монгол улсад сүүлийн үед буюу даярчлалын үед олон салбар ухаанд шинэ шинэ нэр томъёо, үг хэллэг хэрэглэх зайлшгүй шаардлагатай болж байгаа бөгөөд тэдгээрийг монгол хэлний баялаг үгсийн сан, үг бүтэх, үг холбох, хэл зүйн дүрмийн дагуу утгыг зөв оноон, товч оновчтой болгох асуудал тулгарч байна. Ийм нөхцөлд харьцуулсан судалгаа маш чухал юм. Тус өгүүллийг өвөр монголын их сургуулийн нийгмийн ухааны үүдэлтэт баг хийгээд Хятад улсын байгалийн ухааны сан (төслийн дугаар: 60873084)-гийн төслийн хүрээнд бичив.

НОМЗҮЙ

1. Лувсанвандан Ш. (1961) *Орчин Цагийн Монгол Хэл*, Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо.
2. Дондуков Ү.Ж., Жамбалсүрэн Г., Сумъяабаатар Б. (1990) *Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс*, Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.
3. Өвөр Монголын Өөртөө Засах Орны Монгол Нэр Томъёоны Комисс найруулав (1991) *Монгол Нэр Томъёоны Өгүүдлүүд*, Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо.
4. Баатар (1998) *Монгол Үгсийн Сангийн Шинжилгээ*, Үндэстний Хэвлэлийн Хороо.
5. Сэцэнцогт (2004) Дундад Монгол хоёр улсын Монгол нэр томъёоны тухай дөхөмхөн ажиглалт//*Монгол Хэл Бичиг*, долдугар хугцаа, 30-36 х., Хөх хот.
6. Сүмбэрбат Ц. (2008) *Монгол хэлний үгсийн сангийн хөгжлийн асуудал*, Улаанбаатар.
7. Насан М. (2009) *Хятад Монгол үгсийн толь- монгол улс хийгээд Өвөрмонголын харьцуулсан хэллэг*, Үндэстний Хэвлэлийн Хороо.
8. Болдбаатар Д. (2011) *Хятад-Монгол Толь Бичиг*, Улаанбаатар.
9. Балжинням Н. (2011) *Монгол хэлний хятад ормол үгийн судалгаа*, Улаанбаатар.
10. Дундад Улсын монгол хэлний сонин мэдээний сүлжээ,
<http://www.mgyxw.net/mdls/av/aly.aspx?pid=0&alias=current&mid=3169&wy=P>.
99607465

SUMMARY

In conclusion, in this globalization era, there has come inevitable necessity for Inner Mongolia of People's Republic of China and Mongolia to adopt new terms, words and expressions in various fields. Thus, these new terms should be translated correctly and concisely in accordance with Mongolian language principles of word-formation, inflection and grammar. In this situation, comparative study plays key role. This paper is written within the scope of the project implemented by social science research team at Inner Mongolian University and Natural Science Foundation of China /project number: 60873084 /